



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2026/86/ШТА-НА

Баруун-Урт 2026 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа
Утас: 70518396, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа
Утас: 70512123, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512127, Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/85

Баруун-Урт сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Нэр дэвшигчийн зардлын тайлан, мөнгөн хандивын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх үйл явцыг зохион байгуулахыг ахлах аудитор (С.Ариунбаяр)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 09 дүгээр сарын 27, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тус тус Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал)-д хариуцуулсугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Ариунбаяр), аудитор (А.Мөнхцэцэг), аудитор (Б.Ариунзул) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\1. А тушаал-3 2025 хянуулах.docx

2226010175

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
БҮЛЭГ 1. Ардчилсан намаас нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй байна.....	4
БҮЛЭГ2: Нэр дэвшигч сонгуулийн зардлыг хуулийн хүрээнд зарцуулсан байна.....	5
ДҮГНЭЛТ:.....	5

Товчилсон үгийн тайлбар

АН	Ардчилсан нам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИХН	Иргэний хөдөлгөөний нам
МАН	Монгол ардын нам
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улс төрийн намд хандив өгсөн иргэн хуулийн этгээдийн судалгаа	3
2	Нэр дэвшигчид иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын судалгаа	4-5
3	Улс төрийн намын сонгуульд зарцуулсан мөнгөн хөрөнгө	7
4	Сумын ИТХ-д нэр дэвшигчийн зарцуулсан зардлын задаргаа	8

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх Аудитын зорилт Аудитын хамарсан хүрээ	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэв. Сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан зардал Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Аудитад Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын тайлан, дүгнэлтийн хүрээнд гүйцэтгэв.
---	---

БҮЛЭГ 1. Ардчилсан намаас нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасантай нийцээгүй нь байна.

1.1 Сүхбаатар сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд Монгол ардын нам болон Ардчилсан намаас 2 нэр дэвшигч оролцохоор тухайн шатны сонгуулийн хороонд бүртгүүлсэн байна.

1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т (*Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.*) дагуу тус нэр дэвшигчид Төрийн банканд сонгуулийн зардлын данс нээлгэж тус хуулийн 50.3-т (*Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.*) заасан хугацаанд дансны мэдээллийг Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн.

1.3 Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-т (*Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно.*), 33 дугаар зүйлийн 33.2-т (*Иргэний болон хуулийн этгээдийн мөнгөн хандивыг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд хүлээн авах бөгөөд бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно. Гишүүний татвар болон хандивыг нэг харилцах дансанд байршуулна.*) заасны дагуу анхан шатны намын байгууллага сонгуульд оролцохтой холбоотой зардлын данс нээлгээгүй нь тус хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

1.4 Монгол ардын намаас нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т (*Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.*) заасны сонгуульд оролцсон зардлын тайланд Пантер мидланд аудит ХХК-иар дүгнэлт гаргуулан ирүүлсэн бол Ардчилсан намаас нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй байна.

1.5 Зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй нэр дэвшигчийн мэдээллийг тус хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 (*Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.*), Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.25 хэсэг (*Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.*), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.20-т заасны дагуу арга хэмжээ авахыг Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчид зөвлөмж болгон албан бичгээр хүргүүллээ.

1.6 Монгол ардын намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын Төрийн банкны 2707.....66 тоот дансанд 222233071033 улсын бүртгэлийн дугаартай иргэн Алдарбаян бизнесийн орлогоос 1,200.0 мянган төгрөгийг хандивласан байна.

1.7 Сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй нь хуульд заасан шаардлагыг зөрчиж, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал алдагдах, хандивын эх үүсвэрийг хянах боломжгүй болох, хууль бус санхүүжилт хэрэгжих эрсдэл үүсгэж, сонгуулийн үйл ажиллагааны зохион байгуулалтад сөргөөр нөлөөлөхөөр байна.

БҮЛЭГ2: Нэр дэвшигч сонгуулийн зардлыг хуулийн хүрээнд зарцуулсан байна.

2.1 Монгол ардын намаас нэр дэвшигч нөхөн сонгуульд оролцохдоо 1,199.6 мянган төгрөгийг зарцуулсан нь орон нутгийн ээлжит сонгуультай холбогдуулан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай ” А/67 дугаар тушаалаар баталсан хэмжээнээс хэтрээгүй байна.

2.2 Сонгуульд зарцуулсан зардлыг хуульд заасан эдийн засгийн ангиллаар авч үзэхэд тээвэр шатахууны зардал 200.0 мянга, шадар туслах, ухуулагчийн ажлын хөлс урамшуулалд 999.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

д/д	Харилцагчийн нэр	Гүйлгээний		
		Утга	Огноо	Мөнгөн дүн
1	НИК Петровис	Шатахуун	2026.06.18	200,000.0
2	С.Оюунцэцэг	Менежерийн урамшуулал	2026.06.19	200,000.0
3	Д.Доржпалам	Шадар туслах урамшуулал	2026.06.19	200,000.0
4	М.Оюунчимэг	Ухуулагчийн урамшуулал	2026.06.19	200,000.0
5	Т.Ганзориг	Ухуулагчийн урамшуулал	2026.06.19	200,000.0
6	А.Наранцацралт	Ухуулагчийн урамшуулал	2026.06.19	199,600.0
НИЙТ ДҮН				1,199,600.0

(Эх сурвалж: Дансны хуулга)

2.2 Нэр дэвшигч сонгуулийн менежер, шадар туслах, ухаалагч нартай 2026 оны 06 дугаар сарын 04-ны өдөр гэрээ байгуулж баталгаажуулсан байна. Мөн сонгуулийн мөрийн хөтөлбөр танилцуулах, явуулын хайрцгаар санал авах үйл явцад ажиглагч оролцуулах зэрэгт 01-34 УНС, 06-04 СҮА улсын дугаартай авто тээврийн хэрэгсэл ашиглаж 200.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсныг жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулсан байна.

-----ooOoo-----

ДҮГНЭЛТ:

1. Ардчилсан намаас нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргуулаагүй байна.
2. Нэр дэвшигч сонгуулийн зардлыг хуулийн хүрээнд зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Санхүү Төрийн Сангийн Хэлтэст:

- Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах.

